



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ЗАВХАН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

212800 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2017-01-23 № А/05
танай -ны № т

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн
зардал, хандивын талаарх мэдээлэл

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу Үндэсний Аудитын Газрын харьяа Завхан аймгийн Аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон улс төрийн нам, нэр дэвшигчдийн ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хүлээн авч хяналаа.

Сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс сонгуулийн тухай хуулийн 59.1-д заасны дагуу холбогдох сонгуулийн хороонд 3 намын 571 нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч 6, нийт 577 нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг ирүүлсэн байна.

Сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 228.2 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Үүнээс: 136.0 сая төгрөг нь намаас, 23.8 сая төгрөг нь иргэдээс өгсөн хандив, 68.4 сая төгрөг нь нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө байгаа бөгөөд сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчид нийт 228.2 сая төгрөгийг сонгуульд зарцуулсан байна.

Завхан аймгийн Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс ирүүлсэн сонгуулийн зардлын тайлангаас үзэхэд нэр дэвшигчдэд сонгуулийн тухай хуулинд заасан нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.УЛАМБАЯР